

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
О.НАРАНДЭЛГЭР ТАНАА:

ИЛТГЭХ ХУУДАС

“Худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт, мониторинг хийсэн тухай

2022.11.09

Дугаар.04

Улаанбаатар хот

**НЭГ. ХЯНАЛТ, МОНИТОРИНГЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ**

**1.1. Хяналт, мониторингын зорилго:**

Компанийн худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт, мониторинг хийх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах тухай хууль болон холбогдох журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх, илэрсэн алдаа дутагдлын шалтгаан нөхцлийг тогтоож, цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт гаргаж, зөвлөмж өгч, холбогдох албан тушаалтнаар шийдвэрлүүлэхэд чиглэгдэнэ. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах тухай хууль болон холбогдох журмууд, “2022 оны компанийн хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөө” зэргийг тус тус үндэслэн төлөвлөгөөт дотоод хяналт, мониторингын ажлыг хийж гүйцэтгэлээ.

**1.2. Хяналт, мониторингын хамрах хүрээ**

1.2.1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах тухай хууль”-ийн хэрэгжилт;

1.2.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах журам”-ыг хэрэгжүүлж ажилласан эсэх;

1.2.3. “Шууд худалдан авах журам”-ыг хэрэгжүүлж ажилласан эсэх;

1.2.4. “Нээлттэй тендер шалгаруулалтын журам”-ыг хэрэгжүүлж ажилласан эсэх;

1.2.5. “Тендер шалгаруулалтын онцгой журам”-ыг хэрэгжүүлж ажилласан эсэх;

**1.3. Хяналт, мониторинг хийсэн бүрэлдэхүүн:**

Захиргаа, санхүүгийн хэлтсийн хяналт, мониторингын ахлах мэргэжилтэн  
О.Сайнжаргал

**1.4. Хяналт, мониторингод хамрагдсан хэлтэс:**

Захиргаа, санхүүгийн хэлтэс

**1.5. Хяналт мониторингд хамрагдсан хугацаа:**

2022 оны 1 дүгээр сараас 2022 оны 11 дугаар сар хүртэл

**1.6. Хяналт, мониторинг хийсэн хугацаа:**

2022 оны 10 дугаар сарын 31-нээс 2022 оны 11 дүгээр сарын 09-н хүртэл

“Худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд Захиргаа,санхүүгийн хэлтсээс гаргуулж авсан материалын жагсаалт:

1.	“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2022 оны 3 дугаар улирлын худалдан авах үйл ажиллагааны тайлан
2.	“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2022 оны тодотгосон худалдан авалтын төлөвлөгөө
3.	Нээлттэй тендер шалгаруулалт хийсэн 1 худалдан авалтын баримт, материал
4.	Шууд худалдан авалт хийсэн 19 худалдан авалтын баримт, материал
5.	Шууд гэрээ байгуулсан 1 худалдан авалтын баримт ,материал
6.	Албан хэрэгцээнд суурин компьютер,түүний дагалдах хэрэгсэл худалдан авах тендерийн материал
7.	Албан хэрэгцээнд суурин компьютер,түүний дагалдах хэрэгсэл худалдан авах тендерт шалгарсан “Ай ти Зон” ХХК-ын материал
8.	Албан хэрэгцээнд суурин компьютер,түүний дагалдах хэрэгсэл худалдан авах тендерийн материал “Саммит компьютер технологи” ХХК
9.	Албан хэрэгцээнд суурин компьютер,түүний дагалдах хэрэгсэл худалдан авах тендерийн материал “Өнөтэгш Арвижих” ХХК
10.	Албан хэрэгцээнд суурин компьютер,түүний дагалдах хэрэгсэл худалдан авах тендерийн материал “Бодь электроникс” ХХК

## ХОЁР. ХЯНАЛТ, МОНИТОРИНГЫН ҮР ДҮН

Дотоод хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэхдээ 2021 оны 1 дүгээр сарын 01-ээс 2022 оны 11 дүгээр сарыг дуустал хугацааг хамааруулан хийж гүйцэтгэлээ.

### 2.1 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах тухай хууль”-ийн хэрэгжилт;

#### "ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ" ХХК–ИЙН /ЗАХИАЛАГЧИЙН/ 2022 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

№	Тендер шалгаруулалтын код /6/	Худалдан авах бараа, ажил үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр /7/, нэр, төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төрөл /Бараа, ажил, зөвлөх үйлчилгээ, зөвлөхөөс бусад үйлчилгээ/	Төсөвт өртөг /8/ /мян.төг/	Тухайн онд санхүүжих дүн /мян.төг/	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам, арга
1	2	3	4	5	6	7
<b>Өөрийн хөрөнгө</b>						
1	ХААБ/202201001	Компьютер түүний дагалдах хэрэгсэл	Бараа	147,000.00	147,000.00	НТШ
2		Хэвлэх төхөөрөмж	Бараа	9,500.00	9,500.00	ШХА

3		Проектор	Бараа	2,600.00	2,600.00	ШХА
4		Зургийн аппарат	Бараа	6,000.00	6,000.00	ШХА
5		Дижитал дэлгэц	Бараа	8,500.00	8,500.00	ШХА
6		Сүлжээний рүүтэр	Бараа	2,660.00	2,660.00	ШХА
7		Цаг бүртгэгч төхөөрөмж	Бараа	677.50	677.50	ШХА
8		Интернэтийн холболтын төхөөрөмж	Бараа	2,636.00	2,636.00	ШХА
9		Дуу хураагч, бусад тоног төхөөрөмж /ТУЗ/	Бараа	1,000.00	1,000.00	ШХА
10		Усны цэвэршүүлэгч аппарат	Бараа	726.00	726.00	ШХА
11		Биржийн цахим хуудас	Зөвлөх	19,900.00	19,900.00	ШХА
12		Блокчэйн системийн ашиглалт үйлчилгээний төлбөр	Зөвлөх үйлчилгээ	240,000.00	240,000.00	ГШБА
13		Эрүүл мэндийн үзлэг	Зөвлөхөөс бусад үйлчилгээ	18,000.00	18,000.00	ШХА
14		Системийн веб түвшний гадна халдлагаас хамгаалах төхөөрөмжийн лиценз	Зөвлөхөөс бусад үйлчилгээ	26,783.43	26,783.43	ГШБА
15		Компьютерийн вирусын програм	Бараа	2,138.25	2,138.25	ШХА
16		Сүлжээний хамгаалалтын төхөөрөмжийн лицензийн сунгалт	Бараа	4,848.25	4,848.25	ШХА
17		Оффисын хэрэглээний програм	Бараа	17,091.00	17,091.00	ШХА
18		VMWare лиценз	Бараа	18,400.00	18,400.00	ШХА
19		Санхүүгийн програмын лиценз	Бараа	660.00	660.00	ШХА

20		Амьд малыг биржээр арилжих боломжийг судлаж санал боловсруулах зөвлөх үйлчилгээ	Зөвлөх үйлчилгээ	19,800.00	19,800.00	ШХА
21		Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зөвлөх үйлчилгээ	Зөвлөх үйлчилгээ	19,900.00	19,900.00	ШХА
22		Компанийн клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх зөвлөх үйлчилгээ	Зөвлөх үйлчилгээ	19,900.00	19,900.00	ШХА
		<b>ДҮН</b>	<b>-</b>	<b>588,720.43</b>	<b>588,720.43</b>	

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 07 тоот тогтоолоор батлагдсан “Тодотгосон худалдан авалтын төлөвлөгөө”-ний дагуу 588,720,43 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 22 худалдан авалтын үйл ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах тухай хууль”-ын хүрээнд:

Хуулийн / 6.1 .Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална/ заалтын дагуу худалдан авах ажиллагааны зарчмын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

## **2.2 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах журам”-ыг хэрэгжүүлж ажилласан эсэх;**

Хуулийн 7 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны журам

### **7.1. Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:**

- 7.1.1. нээлттэй тендер шалгаруулалтын журам;
- 7.1.2. тендер шалгаруулалтын онцгой журам;
- 7.1.3. зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам.
- 7.1.4. олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 заалтын дагуу нийт 22 худалдан авалтын үйл ажиллагааны 19 худалдан авалтын үйл ажиллагааг “Шууд худалдан авалтын журам”-ын дагуу, 1 худалдан авалтын үйл ажиллагааг “Гэрээ шууд байгуулах журам”-ын дагуу, 1 худалдан авалтын үйл ажиллагааг “Нээлттэй тендер шалгаруулалтын

журам”-ын дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажилласан байна. Харин 1 худалдан авалт хараахан дуусаагүй байгаа бөгөөд ижил төстэй байгууллагуудаас үнийн санал авах үйл ажиллагаа явагдаж байна.

### **2.3”Шууд худалдан авах журам”-ыг хэрэгжүүлж ажилласан эсэх;**

Хуулийн 8 дугаар зүйл.Худалдан авах ажиллагааны журмыг сонгох

8.1. Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараахь босго үнийг тогтооно:

8.1.1. харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

**8.1.2. шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;**

8.1.3. зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

#### **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫГ СОНГОХОД БАРИМТЛАХ БОСГО ҮНЭ**

(сая.төг)

№	Ангилал	Бараа	Ажил	Үйлчилгээ	
				Зөвлөх	Бусад
1.	Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар	70.0	100.0	-	70.0
2.	Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар	20.0	20.0	20.0	20.0
3.	Зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох төсөвт өртгийн дээд хязгаар	-	-	70.0	-
4.	Цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлэх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаар	20.0	20.0	20.0	20.0

**7.3. Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно.**

“Худалдан авах үйл ажиллагааны журам”-ын дээрх 7.3 заалтын дагуу үнийн дүн нь, босго үнэ 20 саяаас бага төсөвт өртөг бүхий 19 худалдан авалтыг “**Шууд худалдан авалтын арга**”-ыг ашиглаж худалдан авалтын үйл ажиллагааг гүйцэтгэсэн байна.

Шууд худалдан авалтыг аргаар зохион байгуулсан худалдан авалтын 90 орчим хувь нь компьютер тоног, төхөөрөмж бөгөөд электрон бараа нийлүүлэгч томоохон компаниудын үнийн болон баталгаат хугацааны саналуудыг харьцуулан судалж, “Бэст комьютер технологи” ХХК, “Саммит комьютер технологи” ХХК болон “Номин Холдинг” ХХК гэх мэт салбартаа тэргүүлэгч компаниудыг Гүйцэтгэгчээр сонгосон байна.

## 2.4. "Нээлттэй тендер шалгаруулалтын журам"-ыг хэрэгжүүлж ажилласан эсэх;

8.2. Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.

"Худалдан авах үйл ажиллагааны журам"-ын дээрх 8.2 заалтын дагуу үнийн дүн нь босго үнээс дээш 147 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Компьютер түүний дагалдах хэрэгсэл"-ийн худалдан авалтыг "Нээлттэй тендер шалгаруулалтын арга"-ыг ашиглан худалдан авалтын үйл ажиллагааг гүйцэтгэсэн байна.

2022 оны 1 дүгээр сарын 24 -ны өдрийн Гүйцэтгэх захирлын А/09 дугаар тушаалаар Үнэлгээний хороог 5 хүний бүрэлдхүүнтэйгээр байгуулсан бөгөөд Төрийн бус байгууллагын 2 төлөөлөл Үнэлгээний хорооны гишүүнээр сонгогдон ажилласан байна.

Үнэлгээний хорооны гишүүнээр сонгогдсон бүх гишүүд ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн байна. Бараа худалдан авах тендерийн баримт бичгийг хууль, журманд нийцүүлэн боловсруулж, тендерт оролцох сонирхолтой аж ахуйн нэгжүүдэд зохих журмын дагуу хүргүүлсэн байна.

"Компьютер түүний дагалдах хэрэгсэл"-ийн худалдан авалтын "Нээлттэй тендер"-ийг 2022 оны 3 дугаар сарын 14-нд зарлаж, 4 сарын 14-нд худалдан авалтын цахим системд тендерийн үр дүнг оруулсан байна.

Тус нээлттэй тендерт 4 аж ахуйн нэгж "Бараа худалдан авах тендерийн баримт бичиг"-ийн дагуу тендерийн баримт бичгийг бүрдүүлэн оролцсон бөгөөд Тендерийн хороо 3 удаа хуралдаж дараах шийдвэрийг гаргасан байна.

д/д	Тендерт оролцогч	Үнийн санал /төгрөг/
1	"Ай ти Зон" ХХК	146.757.600
2	"Бодь электроникс" ХХК	163.471.000
3	"Саммит" ХХК	171.580.000
4	"Өнө тэгш Арвижих" ХХК	168.000.000

Тендерийн хорооны гишүүн бүр, дээрх тендерт оролцсон аж ахуйн нэгж бүрт үнэлгээ өгч, санал нэгтгэйгээр "Бараа худалдан авах тендерийн баримт бичиг"-т заасан бүх шаардлагыг ханган, хамгийн бага үнийн санал өгсөн "Ай ти Зон" ХХК -г тендерийн ялагчаар тодруулж, бараа нийлүүлэх гэрээ байгуулсан байна.

## 2.5. "Тендер шалгаруулалтын онцгой журам"-ыг хэрэгжүүлж ажилласан эсэх;

Хуулийн 34 дүгээр зүйл. Гэрээ шууд байгуулах арга

34.1. Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараахь нөхцөлд хэрэглэж болно:

34.1.1. Энэ хуулийн 30.4.3, 36.18-д заасан тохиолдолд;

34.1.2. Оюуны өмчийн эрх, соёлын биет өвийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол;

34.1.3.Нэмэлт нийлүүлэлт нь анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол;

34.1.4. Нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол;

“Тендер шалгаруулалтын онцгой журам”-ын **34.1.2 заалт**, 2019 оны 7 дугаар сарын 19-ны өдөр байгуулсан “Айтүүлс” ХХК болон Хөдөө аж ахуйн биржийн хооронд байгуулсан ХААБ/201901001/ дугаар бүхий **“Блокчэйн технологид суурилсан арилжаа төлбөр тооцооны иж бүрэн систем нэвтрүүлэх гэрээ”**-г тус тус үндэслэн “Айтүүлс” ХХК-тай “Блокчэйн технологид суурилсан арилжаа төлбөр тооцооны иж бүрэн системийн ашиглалтанд дэмжлэг үзүүлэх гэрээ”-г шууд байгуулсан байна.

#### **Хяналт мониторингийн зөвлөмж:**

1. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ын худалдан авалтын 80-90 хувь нь тендер шалгаруулалтын журамд заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, зөвлөх үйлчилгээг шууд худалдан авч байгаа бөгөөд гүйцэтгэгчийг сонгох үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулсан талаарх судалгаа, дүгнэлт, Гүйцэтгэгчийг сонгосон үндэслэлийн талаар баримт материалыг шууд худалдан авалтын баримтанд тусгаж байх шаардлагатай байна.
2. Тендерийн Үнэлгээний хорооны хуралдааны тэмдэглэл болон Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тухай баримт бичгийг, Үнэлгээний хорооны гишүүн бүрийн гарын үсгээр баталгаажуулах ажлыг бүрэн гүйцэд хийх шаардлагатай байна.

Хяналт, мониторингын зөвлөмжийн хүрээнд хийсэн ажил, үр дүнгийн тайланг 2022 оны 12 дугаар сарын 15-нээс өмнө Захиргаа, санхүүгийн хэлтсийн хяналт, мониторингын ахлах мэргэжилтэн О.Сайнжаргал-д илгээнэ үү.

Хяналт мониторинг хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн хяналт, мониторингын ахлах мэргэжилтэн  
О.Сайнжаргал